



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НТАГ-ЫН 2023 ОНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС

АГУУЛГА

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ОНЦЛОГ
3. БАРИМТАЛСАН БОДЛОГО, ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМ СОРИЛ
4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН
 - 4.1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил
 - 4.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
 - 4.3. Шилэн дансны хуулийн хэрэгжилт



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн тайлангийн аудит нь аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах зорилготой.

Аудитыг хийж гүйцэтгэхдээ Төсвийн тухай, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандарт, Санхүүгийн аудитын удирдамж-Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын Стандарт 1000-1810, 4100-4200, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлаж гүйцэтгэлээ.

2. АУДИТЫН ОНЦЛОГ

Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн онцлогийг дурдвал:

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.10-д заасан цаглабарын дагуу шалгагдагч этгээдийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /эдийн засгийн зорилтод түвшний гүйцэтгэл/-д аудит хийхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг чиглэл болгож байна. Үүнд:

- ✓ Монгол улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого болон төсвийн бодлого хоорондын уялдаа, түүний төлөвлөлт, хэрэгжилт;
- ✓ Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх нийцлийн аудитын зарим асуудал /аудитын шалгуур үзүүлэлтэд хамаарах хууль, тогтоомжид орсон өөрчлөлт/;
- ✓ Тайлант онд УИХ болон ЗГ-с гаргасан шийдвэрийн хэрэгжилт, Сангийн сайдын 2023 оны "Хөтөлбөр батлах тухай" 65 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын хэмжээнд мөрдөх аккрузал суурьт улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- ✓ Аудитын явцад анхаарах бусад асуудал.

Нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг <https://www.open.audit.mn/> цахим хуудаснаас үзнэ үү.



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР

3. БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ГОРИМ СОРИЛ

Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан "Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал", Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий, чиглэл, "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар", бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дээрх бодлогын баримт бичгүүдийг тусгасан нэгж байгууллагын аудитын төлөвлөгөөний хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхдээ дараах горим, сорилуудыг хэрэгжүүлсэн болно. Санхүүгийн тайлагналын аудитаар гүйцэтгэвэл зохих горим сорил Аудитын дүгнэлт гаргах болон түүвэрт хамруулж, үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэх байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөөнд дараах асуудалд анхаарал хандуулахыг чиглэл болгосон байна.



Шалгагдагч байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өмнөх аудитаар тодорхойлсон анхаарал татсан, тулгамдаж буй болон эрсдэл бүхий асуудлыг тодорхойлж, горим сорил хэрэгжүүлэх;



Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн өөрчлөлтийн тайланд гарсан томоохон өөрчлөлтүүдийн шалтгааныг тодруулж стандарт, хууль эрх зүйн нийцэлтэй эсэхэд горим, сорил хэрэгжүүлэх;



Байгууллагын эзэмшил /өмчлөл/-д байгаа газрын судалгааг сүүлийн 5 жилээр авч, гэрчилгээ, кадастрын зурагтай тулган баталгаажуулах, эзэмшил /өмчлөл/-ийн газраас хувийн болон төрийн бус байгууллагад аливаа хэлбэрээр шилжүүлэх, ашиглуулах, ажилчдын орон сууц бариулах зэрэг шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн тохиолдолд уг асуудалд эрсдэл тооцож, биет горим сорил хэрэгжүүлэх;



Төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, түүний үр дүн, хөрөнгийн бүртгэл;



Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, хандив тусламжаар ирсэн хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгасан эсэхэд горим, сорил хэрэгжүүлэх.



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР

АУДИТЫН ХУУЛИЙН
ЭТГЭЭД

93



НТАГ

870



963

НИЙТ СТА



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" 2023 оны А/75, А/160, НТАГ-ын дарга, Тэргүүлэх аудиторын 2023 оны А/26 дугаар тушаалыг үндэслэн 963 санхүүгийн тайланд аудит хийхээс 870 санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газар, 93 санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээд гэрээний үндсэн дээр аудит хийлгэхээр батлагдсан.

НТАГ нь төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 9, шууд захирагчийн 133, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 17 нийт 260 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 710 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн.

160
Санал дүгнэлт
гаргах



710
Үе шатны
ажлыг
хэсэгчлэн хийх



870 СТА





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР


Нийцлийн аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн /мян.төг/



Санхүүгийн аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн /мян.төг/



Санал дүгнэлтийн хэлбэр



Өөрчлөлтгүй

222

87.7%

Хязгаарлалттай

29

13.1%

Сөрөг

2

6.9%

Нийт 598.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс:



Аудитаар дүгнэлт өгсөн 253 шалгадагч байгууллагаас 222 буюу 87.7% нь "Өөрчлөлтгүй санал дүгнэлт", 29 буюу 13.1% нь "Хязгаарлалттай санал дүгнэлт", 2 буюу 6.9% нь "Сөрөг санал дүгнэлт"-ийг тус тус өгсөн. Аудитаар нийт 598,533,143.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс санхүүгийн тайлангийн аудитаар 188,524,475.5 мянган төгрөгийн 2098 зөрчил, нийцлийн аудитаар 410,008,668.0 мянган төгрөгийн 463 зөрчил тус тус илрүүлсэн.



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар нийт 359,365,190.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 17,210,815.4 мянган төгрөгийн зөрчилд 45 албан шаардлага, 23,829,311.7 мянган төгрөгийн зөрчилд 145 зөвлөмж, 318,325,063.1 мянган төгрөгийн 3 зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Төсөвт байгууллагын хүрээнд мөрдлөг болгож байгаа бусад хууль тогтоомжийн хүрээнд аудитаар нийт 50,643,477.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 28,447.0 мянган төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 34,394,473.3 мянган төгрөгийн зөрчилд 84 албан шаардлага, 16,220,557.5 мянган төгрөгийн зөрчилд 176 зөвлөмж, 318,325,063.1 мянган төгрөгийн 3 зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн.



ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

1

Санхүү бүртгэлийн ажилтны чадавхыг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

2

Он дамжсан, насжилт өндөртэй авлагыг барагдуулах үр дүнтэй ажил зохион байгуулах;

3

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шинэчлэлт хийх

4

Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон санхүү төсвийг захиран зарцуулахтай холбоотой хууль дүрэм журмыг мөрдөн ажиллах

5

Төрийн аудитын байгууллагын өгсөн шийдвэрийг хэрэгжүүлж, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байхад анхаарч дотоод хяналтыг сайжруулж ажиллах